

АЛТАН АРСАМЖ

VOL.3

1/2000

“БУРХАН ХАЛДУН” ГЭДЭГ УГИЙН ГАРАЛ, БҮТЦИЙН ОНЦЛОГ

МУИС, МСС-ийн багш
шинжлэх ухааны доктор М.Базаррагчаа.

Монголын нууц товчооноо. Тэмүжин ака нар, дэгү нар морилажу, эртэ бөгэд Бурхан жүг гарба (100) Гачаган амин-ийан кайралган гача мориту кангагау-ийн нору норуллажу калкасун гэр гэрлэн Калдун дээр гарулга би. (§103) Ганцхан амиа хамгаалж, ганц морьт болж, хандгайн жимийг дагаж, халхсан гэр гэрлэж, Халдун дээр гарлаа би (Д.Цэр – 1990, 71-72-р тал) гэж “Бурхан Халдун” гэсэн үг нь тус тусдаа бие даан хэрэглэгдэж байна. Мөн Калдун – Бурхан-а карача-уйн мэдүй амин-ийан калкалагдаба – жа би. (Халдун бурханаар харцын төдий амиа халхлагад ав би (Д.Цэр – 1990, 12-р тал) гэж “Бурхан халдун” гэхийг “Халдун бурхан” гэж байрыг тогторгож хэлдэг байна.

Үүнээс үзвэл энэ хоёр үг нь нийлмэл үг биш, харин нэг нь нөгөөгөө орлох ба байраар нь сэлгэн хэрэглэж байсан тул хоршоо үг ажээ. Энэ хоршоо үг ямар утгатай вэ гэвэл тодорхой биш юм. Б.Ринчен “Тухайлбал Хянганы зузаан ой хөвчөөр ан гөрөө хийж явдаг Бодхан дагай гэдэг монголын нэгэн аймгийн аялгуунаа энэ үг буй. Тэд төлөв бөөгийн мөргөл эдүгээ хүртэл хадгалсаар ирсэн, ангаар амьдрагч ойн иргэн бөгөөд уд модны нам, нэгэн зүйл бүртасыг халдун гэнэ. Тэд өгүүлэх нь энэхүү халдун гэгч мод бусад уд модны зүйлийг бодвол, баахан өндөрлөг газар ургах дуртай мод гэнэ. Бодхан хүн энэ модоор эртнээс нааш онгодын хөргийг дүрслэн хийсээр иржээ. (Б.Рин. – 1944, 28-29-р т) гэж тайлбарлажээ. Ийнхүү хөгшин уд модыг онголон тахисныг бурхан

халдун гэж хэлдгээс уламжилж ирсэн нэр гэж тэрээр үзсэн ба бурханыг ариун, халдуныг бүртас гээд” энэ үг нь ариун бүртас (святая ива) гэсэн утгатай гэж тайлбарлажээ. (Б.Рин. – 1950 (1968) стр. 120). Х.Пэрлээ “XVIII зууны үеийн бололтой нэгэн манж бичигт, Хэнтий уулын судал – Бурхан хада уул маш өндөр, Хэрүлэн, Онон, Тула гурван голын эх газар” гэснийг ишлээд “одоогийн Их хэнтий, Бага хэнтий хоёрын хоорондох Хэнтийн гол нуруунд оролцсон уулсыг ерөнхийд нь Бурхан халдун гэж нэрлэж байсан байна. (Х.Пэр. – 1958, 6-р т) гэжээ. Дээр дурдсан “бодха” гэсэн үг нь зөрчинөөр “анчин гөрөөчин” гэсэн үг ажээ.

С.Дулам “Бурхан халдун” уул гэдэг нь “өвгөдийн бүртастай уул” гэсэн шиг утгатай бөгөөд бүр эрт цагтаа бол “бүртасны эзэн” гэсэн утгаар Халдун бурхан гэж нэрлэж байсан ч байж болзошгүй” (С.Ду. – 1989, 56-р т.) гээд “бурхан” нь “бу-та, бу-р-га-су” (бут, бүртас)-ны эзэн бөгөөд бурх, бурхан гэдэг нь “өвгөн” гэсэн утгатай хэмээн үзсэн тул “Бурхан халдун” уулыг “өвгөдийн бүртастай уул, халдун бүртас бүхий өвгөдийн алтан өлгий” гэж тайлбарлажээ.

М.Ууганбаяр “Бурхан халдун гэдэг нь ижил утгатай хоршоо үг бөгөөд энэ үг нь “оршуулгын газар”, “өвгөд, дээдэс онгон” гэсэн утгатай гээд кала калабагай (эцэг, өвгөд), дагуур хэлний ка-ла (овог аймаг, өвөг дээдэс) гэсэн үгтэй “калдун” хэмээх үг гарлаараа нэг (М.Уу. – 1994, №139) гэж үзсэн байна. Миний бие энэ хоёр үгсийн утгын тухай “бурхан” (эцэг өвгөд, хөгшид) “калдун, калтун” (эмгэд, хөгшид) гэсэн “эр эм” утга бүхий эсрэг утгат үг хоршсон (М.Баз. – 1996, 16-17-р т) гэж үзсэн билээ. Мөн “Калдун” хэмээх үгсийг “катун” (хатан), э-жи (ээж) хэмээх үгсийн хувилбар байж болно гэсэн таамаг дэвшүүлсэн билээ.

С.Ш.Чалдурав “хатан” хэмээх үг нь каты (газрын эзэн)+ ан (амьтны эх) гэсэн хоёр үг нийлж, катун (ээгтэй, хатан) хэмээх үг бүтжээ. (С.Ш.Чал. – 1980, стр. 112) гэж үзсэн байна.

Ш.Цэцэнцогт “буркай” хэмээх үгсийг “хуланц дээдэс” гэсэн утгатай гээд түрэг уйгар хэлнээ “борун” (урьд, дээд) гэсэн үг буй бөгөөд борукан борук акаи (урьдас, дээдэс) гэсэн үг ч бий (Ш.Цэц. – 1987, 775-р т) гэж тайлбарласан байна. Тэрээр “буркан” хэмээх нь “борукан, боркай” гэдгийн олон тоо гээд, буркан нь өвөг дээдэс, дээдэс шүтээн, бурхан халдан гэж тайлбарлан, “бурхан - бу-дда” гэ”эн хоёр үг гарлын сүлбээгүй гэж үзжээ.

Монголын нууц товчооны "Чима-ий дэ ү кэмжү йосун боркаи – ийн мину босога – ийн бо ол, элинчүг-үн мину эүдэн-ү эмчү богол кэмжү илгү-ий мину зйиму (180) (J.Le.Rach. – 1971.р.91) (Чамайг дүү хэмээх (болсон) ёс: буурлын минь босгын боол, элэнцийн минь үүдний боол хэмээж илгээсэн минь ийм. (Д.Цэр. – 1990, 146-147-р т.) гэсний "боркан" (борхой, бурхай) хэмээх үгийг Элдэнтэй, Ардажав нар "хуланц өвөг" (элэнц өвгийн эцгийг хуланц өвөг) (Элд., Арда. – 1986, 540-р т.) гэжээ. Тэгвэл Д.Цэрэнсодном "буркан" гэдгийг хятад хадмал орчуулгад элэнцийн эцэг буюу хуланц аав гэж орчуулсан гээд, энэ үг нь эртний түрэг, монгол хэлний "буурал сарал" гэсэн утгатай бору (бор) гэдгээс үүссэн байж болох юм. Чухамдаа уг үгсийн утга нь өвөг дээдэс буюу буурлын үе гэсэн утгатай бололтой Монголчуудын өөрөөс дээш долоон үеийн тоололд эцэг, өвөг, элэнц, хулан, холбух" гэсэн байна. (Д.Цэр. – 1990, 398-р т.) гэжээ.

Энэхүү "бурхан" нь бура (бур - бургас), бурага (бураа), бургасу (бургас-уяхан мөчиртэй, нарийн навчтай бутлан ургадаг мод), бура – (бурах) зэрэг үгээс эхтэй бөгөөд гагцхүү "р"-ын арын "а" эгшиг гээгдэж, уул үе – утгалбар задран, "р" авиа – утгалбар салаалжээ. Энэхүү "бу-ра" гэсэн хоёр үеийн завсар онцолсон утга бүхий "ту" үе - утгалбар орж, бу-(ту)-ру-л (буурал), бу-(ту)-ру-й (буурай), бу-(ту)-ру-йн-(буурайх) зэрэг үгс нь үүссэн нь "цайрах – хөгшрөх, доройтох" гэсэн утгатай болно. Хэрэв "буркан" гэдгийн "ка" нь "ки" гэж сэлгэвэл "бурки" (бурхи-гурван наснаас дээших бүүдүүн эр тарвата) гэсэн үг үүснэ. Иймд "буркайи – (бурхайх) гэсэн үг нь аливаа амьтны олон нас үеийг элээж бие бялдар нь буурайн бурхайж хөгширснөөс "буркан, буркан" (өвөг дээдэс) гэсэн үг бүтжээ.

Арын эгшгээ гэсэн "р" нь оруулбар бүтээвэр болж, тухайн хоёр бүтээврийн завсар орвол, нэг утга, гээгдвэл мөн нэг утга итгэдэг байна. Өөрөөр хэлбэл, оруулбар бүтээвэр нь монгол хэлнээ үг бүтээх нэг арга хэрэглүүр болсоор ирсэн тул бу-р-ка-н гэдгийн "р" нь гээгдэж, бу-ка-н (бухан, бух) гэсэн үг үүсчээ. Энэ үг нь агталсан эр үхрийг хэлэхээс гадна, "том хүчтэй, эрэлхэг" гэсэн утгатай тул "бух заан, бух тэрэг, бух гөрөөс, Бука катаги, бух цэрэг" гэх зэргээр хэлэлцдэг бөгөөд өөрөөсөө дээш долоодох өвгийг "колабуха" (хол+бух) гэдэг нь "холын бурхай" гэдгийн улбаа юм.

Энэхүү "бука"-аас "бөкэ (бөх тэх), бэки (бэх бат), бака(бах(том) мэлхий, бах тав) зэрэг үг салаалсан ба "том их" гэсэн утгатай "ка" нь "бага жижиг, онцгой" гэсэн утгатай "га, гз"-тэй сэлгэвэл "бага (бага, жиж), булу (буга), бөгз (бөө-элдвээр бүжиглэн, эрчим хүчийг өөртөө хуримтлуулах идтэн) зэрэг үг үүссэн болно.

Эртний буриад монголын шүтээн нь "көкз бука" (хөх бух) байсан (Б.Ц.Цыд – 1972, стр. 280-281) гэж гардаг бөгөөд Жинган "Монгол хэлний бөкэ бука гэдэг үгэнд эртдээ яг аймгийн ахлагч, аймгийн тэргүүлэгч мэтийн утгатай байж билээ... Энэхүү бөкэ бука гэдэг цолтой аймгийн ахлагч буюу тэргүүлэгч нь яг өнөөх хуучны эвэр зүүсэн тушаалтан билээ (Жин. – 1994, 54-р т.) гэж үзсэн байна. Ийнхүү "бука" нь эртний монгол хэлнээ овог аймгийн тэргүүн төдийгүй, тэдний онгон шүтээн, өвөг дээдэс нь байжээ. Тэгвэл "буркан" "бука" хоёр нь утга соёлын хувьд ч, утга зүйн хувьд ч холбоо сүлбээтэй нэгэн зүйлийн холдсон хоёр хувилбар тэмдэг болох ажээ.

Энэчлэн "ка-(л)-дун, ка-л-тун" гэдгийн "л" гэсэн авиа – утгалбар нь гээгдвэл ка-ту-н (хатан-хаад ноёдын эхнэр) хэмээх үг бүтээж, эхний хоёр үе – утгалбарын завсар "га" үе-утгалбар шурган орвол "ка-(га)-ту-н (хаатан-эрхэмсэг хатан, их хатан) гэсэн үг болно.

"Катун" нь "нэг юмыг эвдэх? нэг нь нөгөөг өдөх? өдгөөнөөс үүдэх" гэсэн утга бүхий ка-д-ку – (хатгах), ка-ду-(хадах), ка-ду-р-(хадрах), ка-да-(хадах-шаах), зэрэг үгстэй гарал нэг болно. Эдгээрийн эхний "к" нь гээгдэн тэргүүн үе-утгалбар задарвал, а-да (адах-хадах), а-да-й-р (адайр), а-да-р-(ад-рах), а-да-ра-ма (адармаа), а-да-р-кэ-дэ-р (адар хэдэр) зэрэг нь үүсэж, улмаар э-ту-гэ-н (этүгээн), э-тэ-гэ-д (этгээд), э-жэ-н (эзэн) зэрэг үг үүссэн нь э-дү-(өдөх), э-дү-гэ (эдүгээ), о-дү-а (одоо) зэрэг үгээс эхтэй юм.

Одгээр үгс нь "ка-да-йи – (хадайх), ка-жа-йи (хазайх), ка-жа-ту (хажуу), кө-дэ-л-(хөдлөх), кө-дэ-йн-(хөдийх) зэрэг үгсээс үүсэлтэй тул "катун" хэмээх үг нь 1. өдөөх буюу хамаг юмын уутгал болох, 2. Хажуу эгтээд буюу хажуугийн хань гэсэн утгатай бөгөөд "эвдэх" утга бүхий "ка" нь "ту-с" (тусгах), ту-р-са-(туруших) зэргийн "ту"-язгуураас үүсэлтэй "ту"-тай хоршиж, "ка-ту-н" (хатан) хэмээх үг үүсчээ. Энэхүү "ту" язгуур нь хийсвэрлэн, харьцангуй тэмдэг нэр бүтээх "ту", та-н, та-и зэрэг дагавар болон хувирчээ. "Ка-ту-н" хэмээхийн "ту" нөгөө талаар "ка-да-йи" – э – дү" гэдгийн "да, ду"-

тай сэлгэгч үе-утгалбар юм. Иймд "катун" гэдгийн утгыг "звдэн өдөөж, тусан эзэмдэгч" гэж үгчилж болох ба энэ нь аливаа юмын утгтл бологч буюу ээж гэсэн утгатай юм. Харин "л" оруулбар шурган орж, ка-(л)-ту-н буюу ка-(л)-ду-н болжээ. Энэ "л" оруулбар нь ка-ла-(халан-солих), ка-ла (хал зовлон), ко-ла(хол), ка-ли-су(хальс), ка-л-ча (халц цохих), ка-л-та(халт), кэ-л-тэ(хэлт), э-л-тэ(элт цохих), ко-л-ту (холт), ко-л-ту-су(холтос), ка-л-та-й-й(халтайх), ка-л-ча-ра-(халцрах) зэрэг үгийн-ла<л бүтээврээс эхтэй бөгөөд ка-да-(хадах), ка-ду-(хадах, хяргах) зэргийн "да, ду"-тай сэлгэснээс үүссэн ажээ. Иймд "да, ла" гэсэн хоёр бүтээвэр нь "ка" язгуурын ард хоршин орохдоо өөр хоорондоо сэлгэж байсан тул "ка-л-ду-н" гэж хэлэгдэх болсон байна. Үүнийг

ла
ка
(халдун - хатан)

ГЭЖ ЗАГВАРЧИЛЖ БОЛНО.

Энэхүү үгсийн “ка” нь “эвдэх” утгатай тул ка-л-да (халдах – довтлох, хавьтах) хэмээх үг бүтэж, “да” нь “та”-тай сэлгэж, “к” нь гээгдвэл, а-та-га (атаа), а-та-ку/а (атах - үүрэг тушаал зэргийг хавсран гүйцэтгэх), а-та-в-чи(атавч-тохом шатах холбоо) а-та-л-га (атлаа – матигар иртэй нэгэн зүйлийн оолъ), а-та-га (атаа тэнгэр, атаа жетөө), а-д-ка-г (атгах сэтгэл) гэсэн үг үүссэн нь “бусдыг эвдэх → бусдад мөчөөрхөх гэсэн утгат үгс салаалж, үүнээс э-чи-гэ(эцэг)-“өдөөгч гэсэн утгатай байжээ), ө-чө(эц-эцэг) хэмээх үг бүтсэн нь “э-жи (ээж)>ка-ту-н (хатан)-тай гарал нэг юм. Өдөн уутгачийг “эчигэ” (эцэг) гэсэн ба өдсөнөөс үүдэгчийг эжи(ээж), э-жэ(ээ), а-жа(ээ), э-жэи-н(эзэн)э-чи-(эчих-очих), о-чи-(очих хүрэх – өдөх, нийлэх)” гэх болсон нь солгин нэрлэх ёс юм.

Эдгээр үгсийн "ка" нь, эвдэх → сөдөх, өдөх утгаас гадна, уул юм нөгөөд очих хүрэх гэсэн утгаас "хөндлөөшөө хөдлөх → хажуу тийш болох" гэсэн утгатай юм. Иймээс ка-ту-н"(хатан) нь "хажуу → хажуугийн хүн" гэсэн захын утгыг агуулна. А-та-га: гэдгийн ка-нь "эвдэх", "та" нь хөндлөөшөө холдох", "га: нь гарч бүтсэн юм" гэсэн утгатай болох ба үүнээс "хатгах юм" → хатгагч этгээд гэсэн утга үүсчээ. Харин а-да-, ө-дү-, ө-дү-, о-д-, у-да-, ү-дэ-" зэрэг үгийнн к/с/а... нь "эвдрэх", "-да..." нь "давхарлах, дагах → олшрох" гэсэн

үг бүтэж, өдүүлэгч → үүсэлч" гэсэн утгатай "э-жи (зэж), ү-жин (зэж - эх)>фу-жин-н (зэж гэсэн утгатай хятад гаралтай үг гэдэг), э-жэ(зэ), э-жэ-н(зээн) зэрэг үг бүтжээ. А-та-га(агаа) гэдгийн дэд үе- утгалбар "та" нь "чи" болон сэлгээсэн нь "чи-ли-йи-(чилийн), чи-на-ду(чанад), чи-на-г-си (чанагл), чи-на-р (чана-р "дотоод")>та-ну-р(танар), у-ну-р(үнэр) зэргийн "чи" язгуур сэлгэхээс гадна, "та" нь "ча", "да" нь "жа" болон сэлгэж "ка-ту-н, ка-л-ду-н зэргээр хэлдэг байна гэж загварчилж болно. (М.Баз. — 1996, 3-18-р т.)

Иймээс "буркан калдун" гэсэн үг нь "эр, эм, эцэг, эх гэсэн утгатай бэлгэ тэмдэг онгон шүтээнийг заасан хоршоо үг ажээ. Энэ хоршоо үгийн хувилбар хийгээд түүнээс үүссэн үгсийг харьцуулбал

бу-р-ка-н ка-л-д-н
бу-ка-н ка-л-д-н

гэсэн байдалтай бөгөөд тэргүүн ба дэд үе – утгалбарыг байр сэлгүүлбэл “ка-ту-н”-аас ту-ка(тух) ту-л-ка(тулх) ту-ка-и(тухай), тө-кү-гэ (төхөө), та-ка(тах), то-кү-(тохох), тэ-кэ(тэх-бөх тэх), “бу-ка”-аас ка-бу(ид хав), ка-ба-н(хаван-азарган гахай), ка-бу-л(Хабул хаан), ка-бу-н(хаван), ка-бу-д(хавдах), кэ-б(хэв), кө-бү-н(хөвөн) зэрэг үг саглаалжээ. Жич, дагуур хэлний “ка-л-ду-н”(уд модны мөрөл) гэсэн үг нь ка-ли-су(хальс), ко-л-ту-су(холтос), ко-ли-су(холыс хальс), кү-лү-су(хүлс – хөндий голтой үет модлог ургамал) зэргээс үүссэн бөгөөд у-да(уд-зузаан дүртэй мод), у-да(удах), э-дү-(өдөх), и-да-та-н(удтан), у-д-ка(утга), у-чи-р(учир), у-ча-ра-(учрах), у-ча-р(учир тохиол) зэрэг үгс нь “ка-ту-н”(ка-л-ду-н) хэмээх үгээс үүссэн юм. “Хан Хэнтэй, Хатан Туул гэдгээс үзвэл, ка-ту-н” нь “уян зөөлөн” гэсэн утгаараа ус голыг нэрлэж байсан ажээ. Мөн “Каручидчу Каддуд-та гарбасу...” (Элд., Арда-1986, 471-р т.) гэвэл “Ка-л-ду-н” гэдгийн оруулбар “-л-” нь “д-”тэй сэлгэжээ.

Бурхайн(бурхайх) хэмээх үгийн "б" нь гээгдэх, үе → утгалбар задгайрвал урхайн-(урхайх), уркаг(урхаг), урсиг(уршиг), аркаг(архаг) зэрэг үүссэн ба эдгээрийн "у-р" гэсэн нөхөцмөл язгуур нь у-р(ур), у-ру-г(ураг), у-рэ(үр хүүхэд), р-г: у-г(уг угсаа), у-г-са-га(угсаа) зэрэг үг салгаалах тул "бурхан" гэдэг нь тухайн овог

аймгийн уг шаг буюу өвөг дээдэс гэсэн утгатай юм. Иймд эртний монгол хэлнээ "үг" хэмээх үгсийн эхэнд "б", "этүгээн" хэмээх үгийн эхэнд "к" авиалбар тус тус байжээ.

А.Н.Кононов түрэг хэлнээ огул (хүү) хэмээх үгсийн гарлын тухай эрдэмтдийн саналыг дурдсанаас үзвэл, түрэг хэлний ток(хүүхэд, нялхас), ток-мак(төрөлх), алтай хэл, ик(үг), якут хэл ого(хүүхэд), оголэн(төрөх) зэрэг үгийг харьцуулж, эхний "т" гийгүүлэгч гээгдсэн ажээ. (А.Н.Кононов.-1958, стр.175). Энэхүү "огул"(хүү) гэсэн үг нь монгол хэлний "ү-г(үг)", у-г-са-га(угсаа) гэсэн үгтэй гарал нэг бөгөөд эхэндээ дээр өгүүлсэнчлэн "б" гийгүүлэгч байсан ба бу-г-си-(бүлших), бу-г-ла-(булгах), г-р: cf. у-р-ка-г (урхаг), у-р(ур яр), бу-р-ка-йн-(бурхайх), ба-г(баг), ба-г(баг), б-ф: а-г(аг барих), ба-г-си(багших), ба-г-ла-(баглах), бу-г-си-(бүлших), бу-г-(бүлэх), бө-г-лэ(бөглөх), би-нг(бин битүү) зэрэг үгс нь "ү-г"(үг)-тай гарал нэг юм.

Иш татсан зохиолууд:

- Д.Цэр.-1990. Д.Цэрэнсодном. "Монголын нууц товчоон"-ы орчуулга тайлбар, Хөх хот, 1990
- J.de.Rach. - 1971. J.de Rachewits. The secret history of the Mongols. Translated by (J.de.R.); Papers on Far Eastern History, №9, September. 1971
- Б.Рин. — 1944. Б.Ринчен. "Бурхан халдун гэгч үгийн тайлбар" "Шинжлэх ухаан" сэтгүүл, 1944, №7
- Х.Лэр. — 1958. Х.Лэрлээ. "Нууц товчоонд гардаг газар усны зарим нэрийг хайж олсон нь", УБ, 1958
- Б.Рин. — 1950 (1968). "О зарубежных монголоведных исследований по языку", Улан-Удэ, 1968
- М.Уу. — 1994. М.Ууганбаяр "Бурхан нь мөн оршуулгын газар гэсэн утгатай байх ёстой хэмээн санана" "Улаанбаатар" сонин, 1994, №139(598)
- М.Баз. — 1996. М.Базаррагчаа. Ажнай (Монгол хэлний үгсийн гарал судлалын зарим зүйлс), УБ, 1996
- С.Ш.Чаг — 1980 С.Ш.Чагдунов. Происхождение Гэсэрлады (Опыт сравнительно — исторического исследования Древнего словарного фонда), Новосибирск, 1980

Ш.Цэц.-1987 Ш.Цэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь, Жанг Жива Кэу, 1987

Элд., Арда — 1986. Элдэнтэй, Ардажав. Монголын нууц товчоо — сийрүүлэл, тайлбар, Хөх хот, 1986

Жин — 19 Жин Ган. Арсланы орд монгол бэх

М.Баз.-1996, М.Базаррагчаа. Монгол хэлний "су-н" дагавар ба — "су-н" дагаварт үгийн гарал, УБ, 1996

А.Н.Кононов.-1958. А.Н.Кононов. К этимологии слова "огул"(сын) "Филология и история монгольских народов", М., 1958

Резюме

По мнению автора слова "буркан" возникло от образного слова "буркайн -, баркайн — (бурхайх, бархайх — становиться болышим), а слово "калдун" — от слов кала — (калах — менять), калда-(халдах — нападаты, заразиться). В выше указанных словах в результате выпадения инфиксов "р,л" образуются новые слова "бука(бук-бык — культ бурятских племен) и катун (знатная дама), из которых первое является символом мужского пола, а второе — женского пола. Поэтому вода уподобляется женскому полу, гора — мужскому полу. Примера могут служить словосочетания "Хан Хэнтий, Хатан Туул".